

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 18 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 15 цаг 20 минутад эхэлж, 17 цаг 50 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг 30 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн цахим эмнэлэг хөтөлбөр	Аймгийн цахим эмнэлэг хөтөлбөрийг хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Дорж, аймгийн БОЭТ-ийн захирал Т.Баяртогтох нарт тус тус үүрэг болгов.
2	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох хяналт тавих журам	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох хяналт тавих журмыг хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Гантулгад үүрэг болгов.
3	Өрх толгойлсон эцэг ба эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр	Өрх толгойлсон эцэг ба эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Дорж, Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн Х.Цэцэгханд нарт тус тус үүрэг болгов.
4	Ховд аймагт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх дэд хөтөлбөр хэлэлцүүлэх тухай	Ховд аймагт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх дэд хөтөлбөр хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Гантулга, Хөдөлмөрийн хэлтсийн дарга С.Эрдэнэчимэг нарт тус тус үүрэг болгов.

5	Ахуй үйлчилгээний салбарыг дэмжих дэд хөтөлбөр хэлэлцүүлэх тухай	Ахуй үйлчилгээний салбарыг дэмжих дэд хөтөлбөр ийг аймгийн бодлоготой уялдуулахад анхаарч хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Гантулга, Хөдөлмөрийн хэлтсийн дарга С.Эрдэнэчимэг нарт тус тус үүрэг болгов.
---	--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 19 ДҮГЭЭЭР ХУРАЛ

Хурлыг 2014 оны оны 11 дугаар сарын 25-ны өдрийн 08 цаг 45 минутад эхэлж, 23 цаг 50 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 14 цаг 05 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Архигүй, тамхигүй Ховдчууд” хөтөлбөрийн тухай	“Архигүй, тамхигүй Ховдчууд” хөтөлбөрийн төслийг хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Оюунцэцэгт үүрэг болгов.
2	Мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр орон нутагт баримтлах бодлогын тухай	Мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр орон нутагт баримтлах бодлогыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч Ч.Чинбатад үүрэг болгов.
3	Эрх чөлөөний гудамж байгуулах тухай	“Эрх чөлөөний гудамж” байгуулах саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов.
4	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хэлэлцээд 58.9 хувийн биелэлттэй гэж үзээд “Хангалттай” үнэлж, биелэлтийг танилцуулах явцад гарсан нэмэлт саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж

		шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батмөнхөд үүрэг болгов.
5	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов.
6	Аймгийн 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай	<ol style="list-style-type: none"> 1.Ахуй үйлчилгээний төвийн хажууд, Номингийн эсрэг талд мөн Тахилт багийн 8, 9 дүгээр гудамжинд цэцэрлэгийн газар төлөвлөх 2.Гудамж төслөөр нүүлгэж байгаа айлуудад Дулааны 2 дугаар станцын ойролцоо төлөвлөлттэй газар гаргах 3.Шинэ суурьшлын бүсэд 1 га газрыг зочид буудлын цогцолбор газраар төлөвлөх 4.Жаргалант сумын Соёл, спорт цогцолборыг Тахилт багт газрыг төлөвлөх 5. Шатахуун түгээх станц барих газрыг төлөвлөх 6.Мянган угалзатын уурын зуухны газарт доороо граштай биеийн тамирын талбайн газар төлөвлөх 7. Цагдаагийн кабоныг шинэ дулааны станцын ар талд төлөвлөх 8.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас олгож байгаа газраа муруй, хазгай биш тэгш шугаманд олгоход анхаарч ажиллах 8.Аймгийн 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэх явцад гарсан нэмэлт саналуудыг тусгаж, дахин хянуулаад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Ч.Пүрэвдоржид үүрэг болгов.
7	Аймгийн төсвийн 2014 оны урьдчилсан гүйцэтгэл, 2015 оны төсөл	<ol style="list-style-type: none"> 1.Татварын орлогын төлөвлөгөөг 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр гэхэд 100 хувиас доошгүй хувьд хүргэх 2.Аймгийн хэмжээний нийт 66 уурын зуухыг 2014 оны 12 сард багтааж агаарын бохирдлын шинжилгээнд хамруулах талаар аймгийн Засаг даргын захирамж гаргах 3.Агаарын бохирдлын төлбөрийг суулгаж, зөвшөөрлийг 2014 оны 12 дугаар сард багтаан олгож, 2015 оны 1 дүгээр сард төлбөрөө төлж эхлэх

4.Аймгийн Цагдаагийн газрын дарга, Тээвэр, авто замын газрын дарга, Татварын хэлтсийн дарга нар хамтарч 2014 оны 12 сард ашиглагдахгүй байгаа машиныг цэгцлэх

5.Хог хаягдлыг зөөж, тээвэрлэх талаар аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба, Татварын хэлтэс дүрэм журмаа боловсруулж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд өргөн барьж эрх зүйн орчны шийдвэрийг энэ онд багтаан гаргах

6. Санхүүгийн хяналт аудитын алба, зам , барилгын төсвийг авч ногдуулалт гаргаж үзүүлэх

7.Усны татвар Дөргөний усан цахилгаан станц 60,9 сая төгрөг, Мон-Энко ХХК 195.4 сая төгрөг , Шим ус ОНӨААТҮГ 10 сая төгрөгөөр тооцож нийт 33.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх

8.Улсын тэмдэгтийн хураамжийг нэмэгдүүлж 900 сая төгрөгөөр төлөвлөх

9.Төсөвт байгууллагын өөрийн орлогыг дараах байдлаар нэмэгдүүлэх сумдын Соёлын төв 5 сая төгрөг, Булган сум 10 сая төгрөг, аймгийн Хөгжимт драмын театр 80 сая төгрөг, Музей 10.0 төгрөг, Соёл, спорт аялал жуулчлалын газар 14 сая төгрөгөөр төлөвлөж нийт 116.3 сая төгрөгөөр өөрийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж, төсвийн шууд захирагч нарын гэрээнд тусгаж өгөх

9. Санхүүгийн хяналт аудитын алба, олсон орлогыг зориулалтаар үйл ажиллагаанд зарцуулахад хяналт тавих

10.Хөрөнгийн зардалд Иргэний харъяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Баруун бүс дэх газар 150 сая төгрөг, сумдын багийн хүний эмч нарт мотоцикль авахад 40.0 сая төгрөг, БОЭТөв машин авахад 50 сая төгрөг, цаг агаарт зориудаар нөлөөлөхөд 30.0 сая төгрөг, Буянт, Манхан, Мянгад, Дөргөн, Жаргалант сум машин шинэчлэхэд 100 сая төгрөг, Жаргалант сум машин шинэчлэхэд 40 сая төгрөг, Зооноз өвчин судлалын төв машин авахад 25 сая төгрөг, гоц халдварт өвчний хувцас авахад 3.5 сая төгрөг, Тахарын алба машин авахад 20 сая төгрөг, Хилийн мэргэжлийн хяналт машин авахад 18 сая төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба машин шинэчлэхэд 15 сая төгрөг, Цагдаагийн газрыг камержуулахад 80 сая төгрөг, Цагдаагийн газар машин авахад 60 сая төгрөг, Олон нийтийн аюулгүй олон нийт аюулгүй байдлыг хангах тасгийн засварт 2 сая төгрөг, УБ хотод Ховд аймгийн соёлын өдөр зохион байгуулахад 60

		<p>сая төгрөг, Ховд аймгийн нэвтэрхий толь бичиг хэвлүүлэхэд 40 сая төгрөг, Ёслол хүндэтгэлийн өргөөний өргөтгөл хийхэд 60 сая төгрөг, Чандмань сумын бүтээн байгуулалтанд 40 сая төгрөг, Гадаад хамтын ажиллагаанд 15 сая төгрөг, Зэрэг сумын Ахуй үйлчилгээний барилгын үлдэгдэл санхүүжилт Алтайн буйлааст олгох шүүхийн шийдвэрээр 50 сая, Хүрээлэн төсөл альбом хийхэд 45 сая төгрөгийг байгаль хамгаалах сангаас тус тус тусгахаар</p> <p>11.Хог хаягдлын хураамжийг нэмэгдүүлж, хог хаягдлын санд 171.7 сая төгрөг, байгаль хамгаалах санд 58.4 сая төгрөг, орлогыг 1168.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх</p> <p>12.Хүн амын орлогын албан татвар цалин хөлс түүнтэй адилтгах 270.6 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 114.0 сая төгрөг, авто машин өөрөө явагчын татвар 12 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 440 сая төгрөг, газрын төлбөр 28.7 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал 192 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээни хураамж 24.3 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 33.3 сая төгрөг, ойгоос мод ашигласны төлбөр 13.4 сая төгрөг, ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж 40 сая төгрөг нийт 1168.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөх</p> <p>13. 2015 оны төсөлийг хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатар үүрэг болгов.</p>
--	--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 20 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 11 цаг 45 минутад эхэлж, 12 цаг 30 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 45 минут хуралдав.

Д Д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Хөрөнгө гаргах тухай	Удирдлагын Академийн 100 жилийн ойн арга хэмжээнд дурсгалын зүйл олгосон 350000 төгрөг, 2015 онд төрийн албан хаагчдыг чадавхижуулахад 12000000 төгрөг, хөрөнгө гаргах захирамжинд 11151998 төгрөгийг зарцуулж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус гаргахыг зөвшөөрч олонхийн саналаар дэмжив үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 21 ДҮГЭЭР ХУРАЛ**

Хурлыг 2014 оны оны оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 14 цаг 40 минутад эхэлж, 16 цаг 45 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг 05 минут хуралдав.

Д Д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Улсын сайн малчны тодорхойлолтыг дэмжих тухай	“Улсын сайн малчин”-аар Цэцэг сумын Хажинга багийн малчин Авидын Амархүү, Мөст сумын Баянхайрхан багийн малчин Жавзангийн Төмөрөө, Дарви сумын Баянбулаг багийн малчин Рэнцэндоржийн Цэрэндорж, Буянт сумын Цагаанбургас багийн малчин Должинсүрэнгийн Отгонням нарыг, өнгөрсөн жил ҮХААЯ-нд тодорхойлолт нь хүргэгдсэн Үенч сумын Жаргалан багийн малчин Хинатын Бөрбайн тодорхойлолтыг дэмжихээр 2.“Алтан төлийн эзэн”-ээр “Алтан хурга”-ны эзнээр Мянгад сумын Цагаанбулан багийн малчин Бямбын Хаш-эрдэнийг, “Алтан ишиг”-ны эзнээр Мөнххайрхан сумын Хаг багийн малчин

		<p>Чоймболын Оюун нарыг</p> <p>3.“Улсын тэргүүний тариаланч”-аар Буянт сумын Норжинхайрхан багийн тариаланч Идэшийн Батсүх, Буянт сумын Норжинхайрхан багийн тариаланч Цагааны Шинэбаяр, Жаргалант сумын Буянт багийн тариаланч Чулуунхүүгийн Дэмбэрэл нарын тодорхойлолтыг тус тус дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаяр, Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга З.Лувсан үүрэг болгов.</p>
2	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжилтийн явцын тухай	<p>Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц өссөн дүнгээр жилийн эцсийн байдлаар 61.8 хувьтай хангалттай сайн гэж дүгнэгдсэн тул жилийн эцсийн тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн дарга Ц.Оюунцэцэгт үүрэг болгов.</p>
3	Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын тухай	<p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц жилийн эцсийн байдлаар 82.5 хувьтай биелэгдсэн тул жилийн эцсийн тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн дарга Ц.Оюунцэцэгт үүрэг болгов.</p>
4	Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах журам	<p>Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов.</p>
5	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх журам	<p>Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн</p>

		бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов.
--	--	---

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР